



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/381

Мандалговь

Архи, согтууруулах ундаа худалдаалах түүгээр үйлчлэхгүй байх өдөр болгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “ж” дэх заалт, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Архигүй амьдралыг цогцлооё” арга хэмжээний хүрээнд 2021 оны 10 сарын 01-ний өдрийг дуусталх хугацаанд аймгийн хэмжээнд сар бүрийн 01, 15, 25-нд архи, согтууруулах ундаа худалдаалахгүй, түүгээр үйлчлэхгүй байхаар тогтоосугай.

2. Архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, баяр ёслол, хурим найр, тэмдэглэлт өдрийг архи, согтууруулах ундаагүйгээр тэмдэглэн өнгөрүүлэх, эрүүл мэндээ хамгаалж нийгэмд үзүүлэх хор уршгаас урьдчилан сэргийлэхийг аймгийн нийт иргэдэд уриалсугай.

3. Архи, согтууруулах ундааны хэрэглээг иргэдийн дунд бууруулах, эрүүл мэнд, эдийн засаг, нийгэмд үзүүлэх хор уршгаас сэргийлэх, архи, согтууруулах ундааны шууд болон шууд бус хор нөлөөллийн талаар нийт хүн амд мэдээлэл өгөх, хязгаарласан цагийн хувиарыг мөрдүүлэн ажиллахыг сумдын Засаг дарга нар, Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг тооцон, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210261